

Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан
зардлыг нөхөн төлөх тухай
ГЭРЭЭ

2015 оны 07 дугаар
сарын 22-ны өдөр

дугаар ХАЗ-2016/231/2016/24

Улаанбаатар
хот

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмалын газар, нөгөө талаас ашигт малтмалын ордын MV-020426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшигч Улсын бүртгэлийн албанд бүртгэлтэй 9011416104 тоот гэрчилгээ, 5720443 тоот регистрийн дугаартай "Арголд" ХХК /цаашид аж ахуйн нэгж/ нь Ашигт малтмалын тухай хууль, Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 81 тоот тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн улсын төсвийн хөрөнгөөр хийсэн Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Баянголын дэнжийн алтны шороон орд дээр хийгдсэн геологийн эрэл-зураглал, эрэл үнэлгээний ажил, нарийвчилсан хайгуулын зардлуудыг улсын төсөвт эргүүлэн нөхөн төлөх нөхцөл, үе шат, төлбөрийн хэмжээ, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэгдүгээр зүйл. Эрэл-зураглалын ажлын зардлын нийт хэмжээ

Төв аймгийн Заамар сумын нутаг дахь Баянголын дэнжийн алтны шороон орд дээр байрлах MV-020426 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд 1979-1981, 1981-1984, 1986-1990 ондуудад улсын төсвөөс нийтдээ 379 897,04 төгрөгийн зардал гарсан бөгөөд ноогдох хэмжээг үндэслэн Засгийн газрын 2007 оны 81 дүгээр тогтоолоор баталсан журамд заасан аргачлалын дагуу тооцоход 284 201 094,34 төгрөг бөгөөд 2016 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн Монгол банкны албан ёсны хаалтын ханшийг /1\$=1950,34/ үндэслэн тооцоход **145 718,74 ам.доллар** /нэг зуун дөчин таван мянга долоон зуун арван найман ам.доллар далан дөрвөн цент/ ам.доллар болж байгааг хоёр тал хүлээн зөвшөөрөв.

Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх эрх, үүрэг

1. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд заасан зардлыг 3 жил ийн хугацаанд төлөх бөгөөд төлбөр хийх өдрийн төгрөг, америк долларын ханшаар тооцож төгрөгөөр эсвэл шууд америк доллараар төлнө.

145 718,74 ам.доллар / нэг зуун дөчин таван мянга долоон зуун арван найман ам.доллар далан дөрвөн цент / ам.доллар
(тоогоор) (үсгээр)

2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2.1-т дурьдсан онуудад хийхээр хуваарилсан төлбөрийг тухайн онд хавсралт 1-д заасан байдлаар Төрийн сан банкны төгрөгийн 900000712 Ашигт малтмалын газрын дансанд хийнэ.

3. Хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр хийсний дараа уг төлбөр Ашигт малтмалын газрын дансанд орсон эсэхийг шалгаж болно.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлийн 2, 3-аар тохиролцсон үүргийн дагуу тухайн улирлын төлбөрөө улиралдаа багтаан хийгээгүй бол

№ХАЗ- 2016/231/34 гэрээ

Ашигт малтмалын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 7 дахь заалтын дагуу хугацаа хэтэрсэн хоног тутам тухайн улиралд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алданги төлнө.

Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын хүлээх үүрэг, эрх

1. Энэхүү гэрээний нэгд заасан нөхөн төлбөрийн хэмжээг нөхөн төлбөр хийхээр тохиролцсон хугацаанд өөрийн санаачилгаараа өөрчлөхгүй.

2. Нөхөн төлбөр хийсэн хугацааг банкинд гүйлгээ хийсэн өдрөөр тооцно.

3. Нөхөн төлбөр хийсэн баримт бичигтэй танилцан төлбөрийн хэмжээ үнэн зөв эсэхийг магадлахдаа төлбөр хийсэн өдрийн америк доллар ба төгрөгийн Монгол банкаас зарласан албан ёсны ханшийг баримтална.

Дөрөв. Бусад зүйл

1. Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.


2. Энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 2 дахь заалтын биелэлтийг Ашигт малтмалын газар болон аж ахуйн нэгжийн төлөөлөгчид хамтран дүгнэж акт үйлдэнэ.

3. Гэрээг гурав хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, нэг хувийг Ашигт малтмалын газар, нэг хувийг ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч тус тус хадгална. Гэрээний хувиуд нэгэн адил хүчин төгөлдөр байна. Гэрээ нь хавсралттайгаа нийт гурван хуудаснаас бүрдэнэ.


4. Аж ахуйн нэгж нь энэхүү гэрээний заалтуудыг биелүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын газар нь шүүхэд хандаж болох бөгөөд шүүх ажиллагаатай холбогдон гарах зардлыг аж ахуйн нэгж хариуцан төлнө.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ:
УУЛ УУРХАЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.БАТТУЛГА



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“АРГОЛД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ч.БЯМБАСҮРЭН




№ХА3- 2016/23/24 гэрээ

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Handwritten signature

Нөхөн төлбөрийн гэрээний
Хавсралт №1



2016 он

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	45 718,74		83.000.000	2017.01.24
4			9.000.000	

цэргийн - 21.739.081 тг. - 2017.06.16

2017 он

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	50 000			
4				

2018 он

Улирлууд	Төлбөл зохих US\$	Төлбөр хийсэн өдрийн төгрөг ба америк долларын ханш	Төлсөн нь	Төлбөр хийсэн он сар өдөр бусад тэмдэглэл
1				
2				
3	50 000			
4				